



Захиргааны нэмэлт хэлтэсийн
актын улсын нэгдсэн санд
2020 оны 02 сарын 06-ны
сүрнийн 4694 дүгээрт бүртгээ.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

“Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх, 9.1.6 дах заалтыг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:


1. “Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулх хорооны 2013 оны 64 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт, 2016 оны 12 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
52 тоот тогтоолын
хавсралт

ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү нөхцөл, шаардлага болон Монгол Улсын олон улсын гэрээ, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, шуудангийн үйлчилгээний технологи ажиллагааны стандартуудыг тус тус мөрдөж ажиллана.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шуудангийн сүлжээ байгуулах, ашиглахад дараах нөхцлүүдийг бүрдүүлнэ.

1.2.1. Шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, хүргэх үйл ажиллагаанд Шуудангийн ажлын байр MNS 5540:2005 стандартын, шуудангийн үйлчилгээнд Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажлын байранд тавих шаардлага MNS 5882:2008 стандартын шаардлагыг хангасан ажлын байртай байх;

1.2.2. Шуудангийн болон харилцаа холбооны салбарын инженер, мэргэшсэн технологийн ажилтнуудаар хүний нөөцийг бүрдүүлсэн байх;

1.2.3. Шуудангийн илгээмжийн зориулалтын хайрцаг, сав баглаа боодол, битүүмжлэлийн наалт нь тухайн үйлчилгээний таних тэмдэгтэй байх.

1.3. Харилцаа холбооны зохицуулах хороогоор хянуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шуудангийн сүлжээний төлөвлөлт, ашиглалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хугацаатай төлөвлөгөө нь тус хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан тусгай зөвшөөрлийн гэрээний салшгүй хэсэг байна.

1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад үйлчилгээний таних тэмдгээ бүртгүүлэн, баталгаажуулж хуулбарыг Зохицуулах хороонд ирүүлнэ.

1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шуудан тээврийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах дараах нөхцлийг бүрдүүлнэ.

1.5.2. Шуудангийн аюулгүй байдлын MNS 5539:2019 стандартын шаардлагад нийцсэн тээврийн хэрэгсэлтэй байх;

1.5.1. Тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардсан илгээмжийг тээвэрлэх, хадгалах стандартын шаардлага, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах;

1.5.3. Шуудан тээврийн ажиллагааг аюулгүй тогтвортой байлгах /нөөц тээврийн маршрут, хяналт хамгаалалт, байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гамшгийн үед ажиллах төлөвлөгөө г.м / хэрхэн хангах тухай төлөвлөгөө графикийг баталсан байх;

1.5.4. Шуудангийн илгээмжийн бүртгэл, хяналтын цахим системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, тогтвортой байдлыг хангах.



ХОЁР. СҮЛЖЭЭ БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Улс хоорондын шуудангийн сүлжээ нь дараах шаардлагуудыг хангасан байна:
- 2.1.1. Улс хоорондын шуудангийн сүлжээний төв нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байх;
 - 2.1.2. Шуудангийн илгээмжийг улс хооронд нэг буюу хэд хэдэн чиглэлээр тээвэрлэн, өөрийн харьяа салбараар дамжуулан үйлчлүүлэгчдэд хүргэх;
 - 2.1.3. Шуудан хүлээн авч, илгээмжийг ялган боловсруулах, солилцох солилцооны төвтэй байх.
- 2.2. Дотоодын шуудангийн сүлжээ байгуулахад дараах шаардлагуудыг хангасан байна:
- 2.2.1. Монгол улсын нутаг дэвсгэрт шуудангийн илгээмжийг 3 буюу түүнээс дээш тооны чиглэлээр тээвэрлэн, өөрийн харьяа үйлчилгээний салбар цэгээр дамжуулан хүргэх;
 - 2.2.2. Дотоодын шуудангийн сүлжээний төв нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төвд байрлах ба шуудангийн салбарууд нь өөр хоорондоо график, маршрутын дагуу үйлчилгээ үзүүлэх;
 - 2.2.3. Шууданг хүлээн авч, шуудангийн илгээмжийг ялган боловсруулах, солилцох, солилцооны төвтэй байх.

ГУРАВ. СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ЧАНАР, ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

- 3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Шуудангийн тухай хуулийн 9.1.6-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон шуудангийн илгээмж хүргэх хугацааны графикт-маршрутыг үйлчлүүлэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлнэ:
- 3.1.1. Ердийн зэрэглэлийн илгээмжийг хотын дотор 2 хоног, аймаг, хотуудын хооронд 5 хоног, бусад газар (улс хооронд, баг г.м)-т 12 хоногийн дотор хүргэсэн байна;
 - 3.1.2. Буухиа зэрэглэлийн илгээмжийг хүргэх хугацаа нь үйлчлэгч хоорондын гэрээнд зааснаар тодорхойлогдох бөгөөд энэхүү нөхцөл, шаардлагын 3.1.1 -т заасан хугацаанаас богино байна.
- 3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Шуудангийн тухай хуулийн 7.1.6-д заасан дүрмийн дагуу шуудангийн технологийн баримт бичгүүдийг хадгална.
- 3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн сүлжээгээр бусад үйлчлэгчийн шуудангийн илгээмжийг чөлөөтэй дамжих нөхцлийг бүрдүүлсэн харилцан холболтын зааглах цэгүүдийг сүлжээндээ тодорхойлсон байна.
- 3.4. Шуудангийн сүлжээний үйлчилгээг тасралтгүй явуулах техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

ДӨРӨВ. ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАРИФ

- 4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.11 болон 6.1.4-т тус тус заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төлнө.



4.2. Шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцан холболтын гэрээг байгуулахдаа Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг журмыг мөрдөж харилцан холболтын тарифыг хянуулж байна.

ТАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН СҮЛЖЭЭНИЙ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасны дагуу дараах журмуудыг боловсруулан баталж, мөрдөн, үйлчлүүлэгчид нээлттэй байлгана:

5.1.1 Шуудангийн тухай хуулийн 7.1.6-д заасан дүрмийн дагуу илгээмжийн лавлагаа хүлээн авах, хариу өгөх журам;

5.1.2 Шуудангийн үйлчлүүлэгчийн гомдол маргааныг хүлээн авах, шийдвэрлэх, хохирлыг барагдуулах нөхөн төлбөр олгох журам.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажилтанд тавих шаардлага MNS 5881:2008 стандартыг мөрдөнө.

5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Шуудангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг мөрдөж ажиллана.

–о о о–

